НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 20 өдөр Дугаар 05 Улаанбаатар хот

Мөнгөн хадгаламжийн 2026 оны хүүгийн доод хэмжээг батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.9.8 дахь заалт, "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банкны системд нөлөө бүхий арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2026 оны хүүгийн доод хэмжээг жилийн 13.94 хувиар баталсугай.

2.Баталсан хүүгийн доод хэмжээнээс доошгүй хувиар банкны системд нөлөө бүхий арилжааны банкуудтай хэлцэл хийх, Монголбанкны тухайн үеийн бодлогын хүү, арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ, арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээний өөрчлөлттэй уялдуулан энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан хувийг өөрчлөх тухай саналыг тухай бүр танилцуулан, тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Б.Батжаргал)-т даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

ДАРГА Т.АУБАКИР